



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 44

Мандалговь

**Барилга байгууламжуудыг  
худалдах тухай.**

“Төрийн болон орон нутгийн өмчийн” тухай хуулийн 77, 31 дугаар зүйлийн 31.1 Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.1 “в” 3.2.6-гийн “а” 4 дүгээр зүйлийн 4.1 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжуудыг Сайнцагаан сумын Засаг дарга, МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт, сумын үнэлгээний комиссын саналуудыг хэлэлцэн Наран багийн гал зуух, склад, халуун ус, моторын граж, Билгэхийн 2 айлын орон сууц, сүү хүлээн авах байр, тэжээлийн агуулах, Далай багийн складын барилгуудыг актлан үнэлгээний комиссын тогтоосон үнээр дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Сайнцагаан сумын Засаг дарга М.Баянсан, Орон нутгийн өмчийн албанд үүрэг болгосугай.



ДАРГА **С.БУДЖАВ**

Аймгийн ИТХТ-ийн 2014 оны ... сарын  
... өдрийн ... -р тогтоолын хавсралт

Барилга байгууламжийг худалдах үнэ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Талбай	Худалдах үнэ
1	Наран чулуун склад	1957	м <sup>2</sup>	52.95	850'000
2	Наран моторын граж	1957	м <sup>2</sup>	20.14	120'000
3	Наран гал зуух	1957	м <sup>2</sup>	47.19	250000
4	Наран халуун ус	1957	м <sup>2</sup>	27.04	160'000
5	Билгэх 2 айлын сууц	1984	м <sup>2</sup>	103.68	5'000'000
6	Билгэх сүү хүлээн авах байр	1984	м <sup>2</sup>	-	850'000
7	Билгэх тэжээлийн агуулах	1984	м <sup>2</sup>	-	1'900'000
ДҮН					9'130'000

Тээврийн хэрэгслийн худалдах үнэ

№	Хөрөнгийн нэр	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Худалдах үнэ
1	Өргөгч кран	Nissan Vannet	Дуа 42-86	1997	4'480'000
ДҮН					4'480'000